

УКРАИНЫ ҮЙЛ ЯВДАЛ ДЭЛХИЙН ХУДАЛДАА, ХӨГЖИЛД ХЭРХЭН НӨЛӨӨЛЖ БАЙНА ВЭ

Далайн захиргаа товчлон бэлтгэв

Эх сурвалж:

“THE IMPACT ON TRADE AND
DEVELOPMENT OF THE WAR IN
UKRAINE”
UNCTAD RAPID ASSESMENT UNITED
NATIONS CONFERENCE ON TRADE
AND DEVELOPMENT 16 March 2022”

ОХУ-аас явуулж буй цэргийн ажиллагааны улмаас дэлхий даяар түүхий эд, бараа бүтээгдэхүүний үнэ нийлүүлэлтийг хэрхэн бууруулах нь одоогоор тодорхойгүй байна. Үүний эсрэг тодорхой арга хэмжээнүүд авч байсан хэдий ч эхний үнэлгээгээр барууны орнуудын түүхий эд, бараа бүтээгдэхүүний үнэ өсөж, нийлүүлэлт мэдэгдэхүйц буураад байна. ОХУ-ын эсрэг авсан эдийн засаг хориг арга хэмжээ нь бараа бүтээгдэхүүний үнэ нийлүүлэлтэд шууд нөлөө сөрөг үзүүлсэн байна. Агаарын орон зайг хязгаарласан арга хэмжээ ОХУ болон Украин улсын нутгаар дамжин өнгөрөх бүх гадаад худалдаа нийлүүлэлтийг улам хүндрэлтэй болгож байна. Хоёр улс нь Евро - Азийг холбосон хамгийн гол улсууд юм.

ОХУ 36 орны агаарын тээврийн компаниудад хилээ хаасан учир Ази, Европыг холбосон тээврийн маршрут сонгохгүй байхыг тээврийн зуучийн компаниуд зөвлөж байна. ОХУ-аас явуулж байгаа цэргийн үйл ажиллагаа нь агаарын тээврийн хүчин чадалд сөрөг нөлөө үзүүлж байна. Тээврийн компаниуд нь илүү урт зам туулж байгаа нь түлш зарцуулалт нэмэгдэж илүү их зардал гаргах болсон тул агаарын ачааны үнийг өсгөж байна. Мөн далайн тээврийн үйл ажиллагааны зардлыг мөн адил өсгөж байна.

2021 онд 1,5 сая тонн чингэлэг БНХАУ-аас Европруу төмөр замаар тээвэрлэсэн байна. Хэрэв эдгээр чингэлгийг далайгаар БНХАУ-аас Европ руу тээвэрлэсэн бол ковидын улмаас түгжрэл ихтэй байсан далайн тээврийн түгжрэлийг 5-8 хувиар нэмэгдүүлэх байсан.

Бодит байдалд чингэлэг тээврийн хөлөг онгоцны түлшний өндөр зардал болон маршрутыг өөрчлөх нэмэгдэл ажиллагаа нь чингэлэг тээврийн хөлөг онгоцны нэвтрүүлэх чадамжийг хязгаарлалтад орууллаа. Энэ нь тээврийн сүлжээний үргэлжилсэн хямралд орж байгаа болон хуурай замын тээврээс далайн тээвэр лүү шилжиж байгаа байдлаас тод харагдаж байна (Ази Европын хоорондох тээвэр).

Украины үйл явдлаас шалтгаалан далайн тээврийн үнэ өсөх магадлал байна.

Гэсэн хэдий ч одоогоор дэлхий даяар чингэлэг тээврийн үнэ өсөөгүй бөгөөд өмнөх онуудад байсан өндөр үнээс бага зэрэг буулгаж эцсийн чармайлтыг гаргасаар байгааг бид мэдэх нь зүйтэй. Үүний шалтгаан нь ковидын хязгаарлалтыг сулруулж дэлхийн хэд хэдэн далайн боомтууд нь аажмаар хэт ачааллаасаа салахын тулд үнийн

хөшүүргийг хэрэглэхгүй байх бүх дэлхийн хандлага юм. Гэхдээ үнийг ингэж барих нь салбарыг удахгүй тэнцвэргүй байдалд оруулах нь харагдаж байна.

Хар тэнгис болон Балтийн тэнгисийн бүсийн нефтийн худалдааны гол тээвэрлэгч болох жижиг хөлөг онгоцнуудын тээврийн зардалд аль хэдийн хүчтэй савалгаа харагдаж эхлэв. Хар тэнгист далайн тээвэр хийдэг Aframax болон Suezmax танкер хөлөг онгоцны орлого 2022 оны 2-р сарын 18-нд өдөрт ойролцоогоор \$10,000 байсан бол 2022 оны 2-р сарын 25-нд \$170,000 гаруй ам.доллар болж өссөн байна. Үндсэн ачаа тээврийн зардал 400 орчим хувиар өссөн байна. Зураг 1-т харуулав.




Зураг 1: Aframax болон Suezmax танкер хөлөг онгоц орлого

2022 оны 3 сард энэ бүсийн танкерийн тариф харьцангуй хэвээр байсан хэдий ч бүх төрлийн хөлөг онгоцных хэвээр биш байна. Ачаа тээврийн үнийн өсөлт нь эдийн засагт ихээхэн нөлөө үзүүлэх шинжтэй байна. UNCTAD-ын гаргасан тооцооллоор Ковид-19 цар тахлын үед чингэлэг тээврийн хөлөг онгоцны тээврийн зардал 1,5 хувиар өссөн ялангуяа жижиг арлын хөгжиж буй орнуудад, далайд гарцгүй хөгжиж буй орнууд, буурай хөгжилтэй орнууд гэх мэт эмзэг эдийн засагтай орнуудад асар их нөлөө үзүүлсэн байна. Хамгийн их үнэ нь өссөн 10 бүтээгдэхүүнийг зураг 2-т, улс орнуудын бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийг зураг 3-т харуулав.

Хамгийн их үнэ өссөн 10 бүтээгдэхүүн



Зураг 2: Бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт хувиар



Зураг 3: Бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт хувиар